



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/06

Баянтал сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.4, 67.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Нийтээр тэмдэглэх баяр болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалтын нийтлэг журам"-ын 2.1.5, Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сар шинийн баярыг тохиолдуулан байгууллагын харьяатай 18 ахмадуудад хүндэтгэл үзүүлэхэд 369,000 (гурван зуун жаран есөн мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцог хавсралтаар баталсугай

3. Дээрх зардалд шаардагдах 369,000 (гурван зуун жаран есөн мянган) төгрөгийг Засаг даргын Тамгын газрын нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлаас зарцуулахыг ерөнхий нягтлан бодогч (Б.Амартүвшин)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн (М.Бодьгэрэл)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Т.ХИШИГНЯМ

Засаг даргын Тамгын газрын даргын
2024 оны 05 сарын 29 өдрийн
А/006 дугаар тушаалын хавсралт

Төсвийн задаргаа

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Бүгд үнэ
1	Аяга	ш	18	5,500	99,000
2	Чокофай	ш	18	3,900	70,200
3	Цэвэр сүү	ш	18	5,600	100,800
4	Хадаг	ш	18	5,500	99,000
	Нийт				369,000